## 2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | - | **1,039,134,250.20** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | - | 127,766,644.10 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | - | 127,466,644.10 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | - | 45,000,000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | 45,000,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | - | 486,092.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210402 | Тээвэр, шатахуун | - | 486,092.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | - | 49,601,710.10 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 49,601,710.10 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 32,378,842.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 32,378,842.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | - | 300,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | - | 300,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 300,000.00 |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 54,866,710.10 |
| 213503 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | - | 54,866,710.10 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 911,367,606.10 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | 911,367,606.10 |
| 220001 | Барилга байгууламж | - | 18,248,192.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 2,836,513.45 |
| 223001 | Бусад хөрөнгө | - | 890,282,900.65 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | - | **1,039,134,250.20** |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 1,039,134,250.20 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 12,310,477.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 1,002,563,273.20 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 17,610,500.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | 6,650,000.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

# 3.АУДИТЫН ТАЙЛАН

## 3.1. Ерөнхий зүйл

Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга Х.Баярлах танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл,

анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч байгууллагын тогтмол зардал, эмийн зардал, хоол хүнсний зарцуулалтын талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-ноос 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Эрдэнэцэцэг хариуцаж хэрэгжүүлэв.

## 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Төр, иргэн, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагаанд тулгуурлан, хүний хөгжлийг хангаж, төрийн албыг чадавхжуулж, үйлдвэрлэл бизнест ээлтэй, ногоон хөгжлийн **ХОТ** болохын төлөө нутгийн захиргааны байгууллагуудыг манлайлан ажиллана гэсэн зорилт тавин ажилласан байна. Байгууллагын үйл ажиллагааны чиглэл нь:

- ✓ *Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангаж, төрийн албаны үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашгийг дээшлүүлж, сайн засаглалыг бэхжүүлэх*
- ✓ *Хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн нийгмийн цогц үйлчилгээг зорилтод бүлгүүдэд шуурхай хүргэх*
- ✓ *Үйлдвэрлэл, бизнест ээлтэй орчин бүрдүүлсэн эдийн засгийн өсөлтийг дэмжиж орон нутгийн санхүүгийн бие даасан байдлыг бий болгох*
- ✓ *Хүн амьдрах эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, байгалийн нөөц баялгаа хамгаалах, зүй зохистой ашиглах замаар ногоон хөгжлийн загвар хот болох*

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор "Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай"*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот ''бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай''*
- *Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот ''төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай*

## 3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор Төр, захиргааны байгууллагын дотоод хяналт болон бусад хяналтын байгууллагууд 2020 онд тус байгууллагад хяналт хэрэгжүүлээгүй, Санхүү, дотоод аудитын газраас 2018-2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийж цалин хөлстэй холбоотой 4302.3 мянган төгрөгийн төлбөрийн акт, дотоод хяналттай холбоотой 15211.0 мянган төгрөгийн албан шаардлага өгсөн байна.

Сумын Төрийн сангаас өдөр тутмын санхүүгийн гүйлгээнд дотоод хяналт хэрэгжүүлсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаа, санхүүд хэрэгжүүлсэн дотоод хяналтын тайлан мэдээ байхгүй байна.

Жаргалант сумын ЗДТГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинд "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинд 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 1332865.5 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 13328.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн 1814219.6 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 18142.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

## 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 354145.8 мянган төгрөгөөр буюу 25.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| АВЛАГА | 44,823.0 | 51,729.7 | 6,906.7 |
| БАРАА МАТЕРИАЛ | 35,735.3 | 43,967.7 | 8,232.4 |
| ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,379,515.5 | 1,718,522.2 | 339,006.7 |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,460,073.8** | **1,814,219.6** | **354,145.8** |
| БОГИНО ХУГАЦААТ ӨР | 0.0 | 16,139.0 | 16,139.0 |
| ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН | 1,460,073.8 | 1,798,080.6 | 338,006.8 |
| **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР** | **1,460,073.8** | **1,814,219.6** | **354,145.8** |

Авлага дансны үлдэгдэл оны эцэст 43967.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Аж ахуйн нэгж байгууллагуудтай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй байна. Өмнөх оны насжилт өндөртэй авлага бууруулаагүй, ажилчидтай холбогдох шимтгэлийн тооцоог илүү төлөөд авлагаар тусгаж төсвийн үргүй зардал гаргасан, цалинтай холбоотой тооцоог татвар, даатгалын байгууллагатай тооцоо хийж тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Урьдчилж гарсан зардлын тооцоо нийлсэн акт байхгүй, өмнөх оны урьдчилж гарсан зардлуудын тооцоо хийсэн эсэх тодорхой бус байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 43967.7 мянган төгрөг болж 8232.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд бараа материалын худалдан авалт өссөн байгаа нь нөлөөлж байна. Бараа материалын зардлаас жаргалант сумын жилийн ажлын тайлангийн сэтгүүл, жаргалант сумын хөгжлийг харуулсан альбом, зарим бараа материалыг орлого авч данс бүртгэлд тусгаж зарцуулаагүй төсвийн үрэлгэн зардлууд гарсан байх эрсдэл байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 1379515.5 мянган төгрөг, оны эцэст 1814219.6 мянган төгрөг болж 339006.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн данс нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 49797.9 мянган төгрөгийн барилга байгууламж, тогтог төхөөрөмжтэй холбоотой хөрөнгө, Аймгийн хөрөнгө оруулалтаас 279512.6 мянган төгрөгийн халуун усны барилга, 43375.4 мянган төгрөгийн ухаалаг худгийн барилга, 45455.1 мянган төгрөгийн бичигтийн постын барилга, 27932,0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, нийт 396275.1 мянган төгрөгийн хөрөнгийг 2020.12.09-ны 195,196 тоот аймгийн ИТХ-ын тогтоолоор үнэ төлбөргүй орлогоор авч, 3712.4 мянган төгрөгийн хөрөнгө сумын ИТХ-ын 2020.12.14-ны 182 тоот тогтоолоор акталж данснаас хасалт хийж тайлагнасан байна. Аймгийн ИТХ-ын тогтоолоор хөрөнгө орлого авах 1345920.2 мянган төгрөгийн хөрөнгө орлого авах тогтоол гарсан байхад орлого авч данс бүртгэлд тусгаагүй, ИТХ-ын 67 тоот тогтоолоор 40669.9 мянган төгрөгийн хөрөнгө актлах тогтоол гарсан байхад хөрөнгөө хэрхэн акталсан нь тодорхой бус байна. Тайлант онд бараа материал, үндсэн хөрөнгийн тооллого хийгээгүй байна.

Өр төлбөр оны эхэнд өрийн үлдэгдэлгүй байна. Оны эцэст 16139.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тайлант онд өмнөх оны өр төлсөн гэж харилцахаас зардал төлсөн байгаа нь хоорондын тооцоо хийгээгүй, санхүүгийн тайлангаар тайлагнаагүй байгаатай холбоотой зөрчил байна. Цалингаас хувь хүнээс суутгасан ашгийн татвар төлөөгүй өр үүсгэж төсвийн орлого бүрдүүлээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл оны эцэст 1798080.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Оны эхнээс 338006.7 мянган төгрөгийн тайлант үеийн үр дүнгээр өссөн байна.

Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1082156.9 мянган төгрөгөөр буюу 57.8 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 1082156.9 мянган төгрөгийн орлогын өөрчлөлтөөс санхүүжилтийн орлого 126287.0 мянган төгрөг, хөрөнгийн урсгал санхүүжилтийн орлого 955869.9 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 875844.8 мянган төгрөгөөр өссөн нь цалингийн зардал 60525.8 мянган төгрөг, тогтмол зардал 12795.4 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 74816.4 мянган төгрөг, хөрөнгийн зардал 727707.2 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү бодлогын өөрчлөлтөөр бүртгэлийн 58.8 мянган төгрөгийн дахин үнэлгээтэй хөрөнгө акталсан зардлын бичилт хийсэн байна.

### 3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Төсвийн төлөвлөлт:**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 915296.0 мянган төгрөгөөр нийт зарлагыг 915296.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Аймгийн төсвөөс үндсэн үйл ажиллагааны зардалд төсвөөс 965297.4 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангаас 10320.0 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны орлогоос 1995.0 мянган төгрөгөөр нийт 977612.4 мянган төгрөгөөр баталсан байна.

**Төсвийн гүйцэтгэл:**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 977612.4 мянган төгрөгийн төсөв баталснаас төсвөөс 965297.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 10320.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 1995.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 977612.4 мянган төгрөгийн төсөв баталснаас төсвөөс 967293.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 10320.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 879.5 мянган төгрөгийн санхүүжилт авч 949039.9 мянган төгрөг зарцуулж 29453.2 мянган төгрөгийн төсвийн хэмнэлт гарган төсөвт төвлөрүүлсэн байна. Төсвөөс санхүүжих 965297.4 мянган төгрөг санхүүжилтээс 967293.6 мянган төгрөгийн санхүүжилт авч төсвөө 1996.2 мянган төгрөгөөр хэтрүүлэн санхүүжилт авсан байна. Туслах үйл ажиллагааны орлого 1995.0 мянган төгрөг оруулах төлөвлөгөө биелэгдээгүй байгаа мэт харагдаж байгаа боловч нэмэлт дансаар 7149.5 мянган төгрөг оруулж үндсэн данс руу 879.5 мянган төгрөг шилжүүлж 1115.5 мянган төгрөгийг дутуу шилжүүлсэн байна. Төлөвлөгөөт орлогоос 1115.5 мянган төгрөг, давсан орлогоос 5154.5 мянган төгрөгийг нэмэлт дансаар оруулж зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 949039.9 мянган төгрөг буюу 92% зарцуулсан байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийн 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн боловч хөтөлбөрөөс хэмнэлт гаргасан байна.

Хөтөлбөр арга хэмжээний хэмнэлтийг хүснэгтээр харуулбал:

| Код | Хөтөлбөр, арга хэмжээ | Мөнгөн дүн |
|---|---|---|
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 8,602.9 |
| 80106 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 4,281.4 |
| 80205 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 2,115.0 |
| 80305 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 205.0 |
| 80918 | Хөрөнгө оруулалт | 14,248.9 |
| **ДҮН** | | **29,453.2** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

**Нэмэлт санхүүжилт:**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансаар аймгийн эрх шилжсэн хөрөнгө оруулалтын санхүүжилт 918264.1 мянган төгрөг, үйл ажиллагааны үр дүнд бий болсон орлого 17990.5 мянган төгрөг, өөрийн туслах үйл ажиллагааны орлогоос 6270.0 мянган төгрөг, хүн амын болон малын тооллогын санхүүжилт 12310,5 мянган төгрөг, Хөшөөт хөгжил сангийн хөрөнгийн санхүүжилт 84299.1 мянган төгрөг нийт 1039134.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Нэмэлт орлогоос хүн амын тооллого болон малын тооллогын зардалд 13232.7 мянган төгрөг, Хөшөөт хөгжил сангийн хөрөнгөөр бичигт багийн халуун усны засвар болон бага оврын автобус худалдан авахад 82269.1 мянган төгрөг, Постын ажилчдын цалинд 44061.0 мянган төгрөг, гудамж талбайн засварт 75789.9 мянган төгрөг, ОНХС-ийн эрх шилжсэн хөрөнгө оруулалтаар 750333.0 мянган төгрөг, дотоод үйл ажиллагааны зардалд 13581.8 мянган төгрөг нийт 979267.5 мянган төгрөгийг зарцуулснаас дутуу хийгдсэн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг олгоогүй 51704.7 мянган төгрөг, үйл ажиллагааны зардлаас хэмнэгдсэн 3162.0 мянган төгрөг нийт 54866.7 мянган төгрөгийг төсөвт буцаан

төвлөрүүлсэн байна. Нэмэлт дансаар орж ирсэн барьцаа хөрөнгө 5600.0 мянган төгрөг, техник хяналтын зардал 1050.0 мянган төгрөгийг зориулалт бус зарцуулсан байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 134 мэдээлэл оруулахаас хугацаандаа оруулсан 114, мэдээллийг огт оруулаагүй 6, мэдээлэл дутуу оруулсан 14 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулахаас 6 мэдээллийг байршуулаагүй байгааг залруулан мэдээллийг оруулсан байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Жаргалант сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлангаар дүгнэлт гаргаагүй түүвэрт хамрагдаж сумын нэгтгэл тайлангийн аудитаар дараах төлбөрийн акт, зөвлөмжийг өгсөн байна. Хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал:

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 1,350.0 | - | - | 1 | 1,350.0 | - |
| Албан шаардлага | - | - | - | - | - | - | - |
| Зөвлөмж | 2 | 28,250.0 | 1 | 750.0 | 1 | 27,500.0 | 33 |
| Нийт дүн | 3 | 29,600.0 | 1 | 750.0 | 1 | 28,850.0 | - |

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар 1572442.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 35833.7 мянган төгрөгийн алдаа залруулж 1536609.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчлөөс 1368.0 мянган төгрөгийн 2 зөрчилд 1 төлбөрийн акт, 183796.7 мянган төгрөгийн 6 зөрчилд 1 албан шаардлага, 1351444.7 мянган төгрөгийн 2 зөрчилд 2 зөвлөмж хүргүүллээ.

**<u>Залруулсан алдаа</u>:** Аудитаар тайлангийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлд 35833.7 мянган төгрөгийн санхүүжилт илүү илэрхийлсэн байгаад залруулга хийгдсэн.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 1368.0 мянган төгрөгийн 2 зөрчилд 1 төлбөрийн акт, 183796.4 мянган төгрөгийн 6 зөрчилд 1 албан шаардлага бичлээ.

***1. Түрээсийн орлого***

*1.1. <u>Илрүүлэлт:</u> Нийтийн эзэмшлийн сурталчилгааны самбар түрээслэн орлого олж холбогдох хууль журмын дагуу түрээсийн орлогын 30%-ийг төсөвт төвлөрүүлээгүй 918.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.*

*1.2. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 03-р сарын 06-ны өдрийн 293 тоот тогтоолын 3.5-д "Түрээслүүлэгч нь түрээсийн төлбөрийн 30 хувийг төлбөр орсноос хойш 5 хоногийн дотор төсөвт төвлөрүүлнэ", Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.*

1.3. *Илрүүлэлт: Жаргалант сумын тухай альбом ном бүтээсэн зардалд ачаа тээврийн үнэ багтсан байхад төсвөөс илүү төлсөн 450.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.*

1.4. *Энэ нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.1-д "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.*

*Шийдвэрлэсэн нь: Түрээсийн орлогын зохих хувийг болон илүү төлсөн ачаа тээврийн хөлсийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох*

## 2. Өглөг, авлага хөрөнгөтэй холбоотой

2.1. *Илрүүлэлт: Цалингаас суутгасан нийгмийн даатгалын шимтгэл илүү төлж төсвийн үргүй зардал гаргасан өмнөх оны авлага бууруулаагүй, цалингийн карт хөтлөөгүй гарын үсэг зуруулж баталгаажуулаагүй 8984.5 мянган төгрөг,*

2.2. *Илрүүлэлт: Цалингаас суутгасан ашиг төсөвт дутуу төвлөрүүлж өглөг үүсгэсэн, тооцоо нийлсэн акт байхгүй цалингийн зардал тайланд бодитоор илэрхийлэгдээгүй 13944.0 мянган төгрөг,*

2.3. *Илрүүлэлт: Батлагдсан төсвөөс цалингийн зардал хэтрүүлэн зарцуулсан, туслах үйл ажиллагааны орлого үндсэн дансанд дутуу төвлөрүүлсэн боловч нэмэлт дансаар орлого олж зарцуулсан 6290.9 мянган төгрөг,*

2.4. *Илрүүлэлт: Насжилт өндөртэй өмнөх оны урьдчилж гарсан дансны авлага бууруулаагүй 44074.3 мянган төгрөг,*

2.5. *Илрүүлэлт: Анхан шатны баримтын бүрдэл дутуу, хөрөнгө орлого аваагүй, зарцуулалтын тайлан байхгүй ажил гүйлгээ хийсэн 36384.2 мянган төгрөг,*

2.6. *Илрүүлэлт: Захирамжаар гарсан хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн тайлан, мэдээ мэдээлэл хангалтгүй, тооцоо нийлсэн акт болон бусад баримт шийдвэрүүд байхгүй дотоод хяналт сул байгаа 67468.4 мянган төгрөгийн зөрчил тус тус илэрлээ.*

2.7. *Илрүүлэлт: Хөрөнгө оруулалтын техник хяналтын зардал, барьцаа хөрөнгийн зардлыг зориулалт бус зарцуулсан 6650.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.*

2.8. *Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах, Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, 6-р зүйлийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.*

2.9. *Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага бичих*

**Аудитын зөвлөмж:** Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 1351444.7 мянган төгрөгийн 2 алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар засаг даргын захирамжийн хэрэгжилт, эрх шилжиж ирж байгаа хөрөнгийн  зарцуулалтыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 1. *Бараа материал*

1.1. *Илрүүлэлт: Өвсний тооцоо хийж үлдэгдлийн баталгаажуулаагүй, авлага өглөг тооцсон акт байхгүй, кассаар их хэмжээний мөнгө оруулж зарцуулж 5524.5 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.*

1.2. *Эрсдэл: Дотоод хяналтын үр дүнг хэрэгжүүлээгүй байх, хөрөнгийн ашиглалт хамгаалалт хангалтгүй байх, санхүүгийн тайлангийн үнэн зөв, иж бүрэн байх батламж мэдэгдэл хангагдахгүй байх*

1.3. *Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах*

1.4. *Байгууллагаас ирүүлсэн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн*

### 2. *Үндсэн хөрөнгө*

2.1. *Илрүүлэлт: Аймгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ИТХ-ын тогтоолоор хөрөнгө орлого авах шийдвэр гарсан байхад хөрөнгө орлого бүртгээгүй, акталсан хөрөнгийн дүн зөрүүтэй 1345920.2 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.*

2.2. *Эрсдэл: ИТХ-ын тогтоол хэрэгжихгүй байх, дотоод хяналтын үр дүнг хэрэгжүүлээгүй байх, хөрөнгийн ашиглалт хамгаалалт хангалтгүй байх, санхүүгийн тайлангийн үнэн зөв, иж бүрэн байх батламж мэдэгдэл хангагдахгүй байх*

2.3. *Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78-р зүйлийн 78.1-д "Засаг дарга нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас орон нутгийн өмчийн эд хөрөнгийн талаар гарсан шийдвэрийг Засгийн газрын бодлогод нийцүүлэн хэрэгжүүлэх үүрэгтэй", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.1-д "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах*

2.4. *Байгууллагаас ирүүлсэн хариу тайлбар: Хөрөнгө орлого авахыг түр хүлээж бай гэж аймгаас үүрэг өгсөн гэсэн тайлбар хэлсэн. Жаргалант сумын нэгтгэсэн тайлангаар дахин хянахаар зөвлөмж өглөө.*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дугээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

| | | | |
|---|---|---|---|
| Огноо: 2021 | Аудитын нэр: | ***Жаргалант сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит*** | Аудитын код: ХОА-2021/15/СТА- |
| Шалгагдсан байгууллагын нэр: | **Жаргалант сумын ЗДТГ** | | Мянган төгрөгөөр |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Хөрөнгө оруулалтын техник хяналтын зардал, барьцаа хөрөнгийн зардлыг зориулалт бус зарцуулсан | 6650.0 | Албан шаардлага | Жаргалант сумын ЗДТГ-ын дарга Нягтлан бодогч | Х.Баярлах, Ц.Өсөхбаяр |
| 2 | Нийтийн эзэмшлийн самбар түрээслээд орлого олж холбогдох хууль журмын дагуу түрээсийн орлогын 30%-ийг төсөвт төвлөрүүлээгүй, ачаа тээврийн хөлс төсвөөс илүү төлсөн | 1368.0 | Төлбөрийн акт | | |
| 3 | Авлага, өглөг их хэмжээгээр үүсгэсэн, насжилт өндөртэй урьдчилж гарсан зардлын авлага бууруулаагүй, анхан шатны баримтгүй гүйлгээ хийсэн, захирамжийн хэрэгжилт хангалтгүй | 177146.4 | Албан шаардлага | | |
| 4 | Өвсний тооцоо хийж үлдэгдлийн баталгаажуулаагүй, авлага өглөг тооцсон акт байхгүй, кассаар их хэмжээний мөнгө оруулж зарцуулсан | 5524.5 | Зөвлөмж | | |
| 5 | Аймгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ИТХ-ын тогтоолоор хөрөнгө орлого авах шийдвэр гарсан байхад хөрөнгө орлого бүртгээгүй, акталсан хөрөнгийн дүн зөрүүтэй тогтоол шийдвэр хэрэгжээгүй | 1351444.2 | Зөвлөмж | | |
| 6 | Үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд санхүүжилт болон зардлын дансыг буруу илэрхийлсэн, төсвийн гүйцэтгэл буруу тайлагнасан | 35833.7 | Залруулга хийсэн | | |
| **ДҮН** | | **1572442.8** | | | |

**ХОВД АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**